



ГОВЬСҮМБЭР АЙМАГ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

Шалгалтанд хамрагдсан объект: “Сүмбэр сумын ЗДТГ”

Шалгалт хийсэн байцаагч: Л.Эрдэнэчимэг
Л.Одонтуяа

Шалгалтанд хамрагдсан тайлант хугацаа: 2022 он

2023 он



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАНИЛЦУУЛГА

2023 оны 06 сарын 06 өдөр

Дугаар ТЦА/2023-26/01-04

Сүмбэр сум,

ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

1. ТАНИЛЦУУЛГА

Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдөр байгуулагдсан, Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд төр, эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллага юм.

Шалгалтад хамрагдах хугацаанд төсвийн хөрөнгийг захиран зарцуулах нэгдүгээр гарын үсгийг П.Наранмандах, хоёрдугаар гарын үсгийг 2022 оны 8 дугаар сарын 4-ний өдрийг дуустал Э.Бямбасүрэн, 2022 оны 8 дугаар сарын 4-ний өдрөөс Б.Болор-Эрдэнэ нар зурж санхүүгийн гүйлгээ хийж хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго

Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн баталсан 04 тоот удирдамжаар Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгаж, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, журмуудын хэрэгжилтийг шалгах зорилгоор хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

2.2. Аудитын цар хүрээ

2.2.1 Сүмбэр сумын ЗДТГ-ын хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт

4202303019

- 2.2.2 Санхүү төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт
- 2.2.3 Харилцах, кассаар зарцуулсан мөнгөний бармитын бүрдэлт, хууль эрх зүйн үндэслэл, зарцуулалт, үр дүн, тайлан мэдээг үнэн зөв тайлагнасан эсэх,
- 2.2.4 Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх
- 2.2.5 Өмнө нь хийгдсэн шалгалтуудын талаар авсан арга хэмжээ, төлбөр зөрчил, түүний барагдуулалт
- 2.2.6 Иргэн аж ахуй нэгж байгууллагатай байгуулсан гэрээ түүний хэрэгжилт
- 2.2.7 Төсвийн тухай хууль болон холбогдох журмуудын хэрэгжилтийн байдалтай танилцаж тулгарч буй асуудлуудыг дүгнэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулахад чиглэгдэнэ.

3. АУДИТЫН ҮР ДҮН

3.1. Илэрсэн асуудлууд

Асуудал 1: Дотоод журам баримтлан ажиллахгүй байна.

Шалгуур: Сумын Засаг тамгын газрын даргын 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/10 тоот тушаалаар шинэчлэн баталсан дотоод журам байна. 12 дугаар заалтын 12.5-т “Албан хаагчид томилолтоор ажиллаж ирснээс хойш ажлын 3 хоногийн дотор томилолтоор ажилласан тухайгаа илтгэх хуудсаар Тамгын газрын даргад тайлагнах ба Тамгын газрын дарга албан хаагчийг дүгнэж, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх талбар олгох журам”-д заасны дагуу албан томилолтын зардлыг тооцож олгоно”, 12 дугаар заалтын 12.6-т “Тайлан, илтгэх хуудсанд албан томилолтоор ажилласан үеийн яриа, хэлэлцээний тэмдэглэл, байгууллагын танилцуулга, шаардлагатай бол фото зураг хавсаргана”, 12 дугаар заалтын 12.7-т “Албан томилолтоор ажилласан албан хаагчид албан томилолтоор ажилласан тайлангаа Тамгын газрын албан хаагчдын дотоод сургалтаар мэдээлнэ” гэжээ.

Бодит нөхцөл байдал 1: 2022 оны 12 дүгээр сарын 17-20-нд сумын Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Э.Сарнай, Санхүүгийн албаны дарга Х.Молор, Төрийн үйлчилгээний операторын ажилтан Ч.Ундармаа, нярав Г.Баяртогтох нар Улаанбаатар хотод ISO стандарт хэрэгжүүлэх талаар 3 хоногийн сургалтад хамрагдаж тус бүр 426.0 мянган төгрөг, нийт 1,704.0 мянган төгрөгийг томилолтын зардлыг холбогдох удирдамж, сургалтад хамрагдсан тайлангүй олгосон зөрчил илэрлээ. Тиймээс дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхыг зөвлөж байна.

Шалтгаан: Дотоод журмыг баримталж ажиллаагүй.

Үр нөлөө: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, үр ашиггүй зарцуулалт хийх

Асуудал 2: Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийжээ.

Шалгуур: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “Тасралтгүй байх”, 5.1.3-д “Жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Тус хуулийн 20 дугаар зүйлд нягтлан бодогчийн эрх, үүргийг зааж өгсөн байдаг. 20 дугаар зүйлийн 20.1.1-т “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;” 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны

баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Маягт заавар батлах тухай” 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.4-д “Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаархи гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудасыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана. НХМаягт ТМ-4”, Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Жишиг норм батлах тухай” 390 дугаар тушаалын 1-д “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд”-ийг 2 дугаар, “Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г 3 дугаар, “Автомашин эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн норм”-ыг 4 дүгээр, “Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм”-ыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай”, 2-д “Автомашин шатахуун зарцуулалтын жишиг норм, шатахуун зарцуулалтын жишиг нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд, автомашин, түүний үндсэн агрегат, зангилаанууд, резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм, түүнийг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцлүүдийг харгалзан өөрсдийн ажил үйлчилгээнийхээ онцлогт нийцүүлэн мөрдөж ажиллахыг автотээврийн байгууллага, аж ахуйн нэгж, автотээврийн хэрэгсэл бүхий иргэдэд зөвлөсүгэй” гэжээ.

Бодит нөхцөл байдал 1: Сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг ажлын байран дээр сургаж дадлагажуулах зорилгоор албан хаагчдын дунд “Мэдлэг бол хүч” арга хэмжээг зохион байгуулахаар Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн А/15 дугаартай хөрөнгө зарцуулах тухай тушаалаар 1,000.0 мянган төгрөгийг зарцуулсан боловч холбогдох

удирдамж, тайлан байхгүй, цахим төлбөрийн баримтаарх нэхэмжлэх байхгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Тиймээс дээрх зөрчлийг давтан гаргахгүй байж анхан шатны баримтыг холбогдох журмын хүрээнд бүрэн бүрдүүлэхийг зөвлөж байна

Бодит нөхцөл байдал 2: Жолоочийн тооцооны хуудсанд тухайн байгууллагын автомашин нь ямар албан тушаалтны албаны ямар хэрэгцээнд замд явсан тухай гүйцэтгэлийг бичдэггүй, 2022 оны 1-7 сар 6,088.8 мянган төгрөгийн тооцооны хуудас нягтлан бодогч тооцоо бодож хянаж баталгаажуулаагүй. Тиймээс дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхыг зөвлөж байна

Шалтгаан: Анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.

Үр нөлөө: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, үр ашиггүй зарцуулалт хийх

Асуудал 3. Засаг даргын нөөц хөрөнгөөс зориулалтын бус зардалд хөрөнгө гаргасан

Шалгуур: Төрийн хэмнэлтийн тухай 12 дугаар зүйлийн 1.4-т “Хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг хориглоно”, 15 дугаар зүйлийн 1.5-т “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно” гэжээ.

Бодит нөхцөл байдал: Монгол улсын төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одон”- гоор шагнагдсан Хишигтийн Чулуунбаатар, Дэлхийн зөн байгууллагад хүндэтгэл үзүүлэх зардалд 1,001.9 мянган төгрөгийн зарцуулжээ. Гэхдээ дээрх зардлыг гаргахдаа холбогдох тайлан гаргаагүй байх тул дээрх 1,001.9 мянган төгрөгийг шийдвэр гаргасан албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж орон нутгийн орлого болгуулахаар улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоолоо.

Шалтгаан: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй.

Үр нөлөө: Засаг даргын нөөц хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Асуудал 4: Архив албан хэрэг хөтлөлтийн ажил хангалтгүй байна.

Шалгуур: MNS 5140-252021 Баримт бичиг. 2-р хэсэг. Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлагын 5.7, 5.8 заалт

Бодит нөхцөл байдал 1: Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн А/15 тоот тушаал “Хөрөнгө зарцуулах тухай” харилцахын баримтад байхад, 2022 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн А/15 тоот тушаал “Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” тушаал гаргаж архивын нэгжид хавсаргасан байна. Иймд эрхзүйн акт болох тушаал гаргасан тухай бүрд журналын бүртгэлийн дагуу архивын нэгж үүсгэж ажиллах.

Бодит нөхцөл байдал 2: Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 4 дугаар сарын 21-ны өдрийн А/10 тоот тушаал “Сумын Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай” 10.11 заалт 2 хувилбартай аль нь хүчин төгөлдөр эсэх нь тодорхойгүй хамт олны хурлын тэмдэглэл бичигдсэн архивын нэгж үүсээгүй. Иймд хамт олны хурлаар батласан дотоод журмыг байгууллагын архив болон цахим мэдээллийн санд нөхөн байршуулсан.

Шалтгаан: Албан хэрэг хөтлөлтийн стандартаа мөрдөх

Үр нөлөө: Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн стандарт алдагдсан байна.

Асуудал 5: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Шалгуур: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:”, Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журам

Бодит нөхцөл байдал: Тус байгууллага нь шалгалтад хамрагдсан тайлант хугацаанд нийт 3 удаа шилэн дансны мэдээлэл хоцроосон. Өмнөх шалгалтын мөрөөр мэдээллийг нэмж оруулсан.

Өмнө хийгдсэн шалгалтуудын мөрөөр авсан арга хэмжээ, төлбөр зөрчил түүний барагдуулалт:

Манай байгууллагаас тус байгууллагын 2020, 2021 оны үйл ажиллагаа холбоотой санхүүгийн баримтад 2022 онд шалгалтын санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Л.Одонтуяа хийсэн. Шалгалтаар нийт 16.573,3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 313,0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоосон байна. Актын төлбөр бүрэн барагдсан байна.

Байгууллагын ололт амжилт:

Тус байгууллагын албан хаагчид харьцангуй тогтвортой ажиллаж байна.

Дүгнэлт

Шалгалтын явцад тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаа холбоотой баримт материалуудыг авчруулан шалгалаа.

Шалгалтаар нийт 9,794.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1,001.9 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоолоо. Дээрх зөрчлийг дахин гаргахгүй байх талаар зөвлөгөө өгч ажиллалаа.

Иймд цаашид авах арга хэмжээний дараах саналыг хүргүүлж байна.

3.1. Зөвлөмж / Цаашид авах арга хэмжээний санал/

3.1.2 Анхан шатны баримтын бүрдэл хангах

3.1.3 Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн гүйцэд хөтөлж байх, норм, хэмжээг баримтлах, шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

3.1.4 Шилэн дансны мэдээллийг оруулахдаа мэдээллийн тайлбар, мэдээлэл оруулах хуулийн хугацаанд нь мэдээлж хэвших

- 3.1.5 Хөдөлмөрийн дотоод журам цаасаар болон файлаар 1 ижил хувьтай байх,
зүйл заалтыг жигд мөрдөж ажиллах
- 3.1.6 Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, анхан шатны баримтын бүрдлийг
хангаж ажиллах, бараа материалын тайланг QR код бүхий төлбөрийн баримт,
цахим илгээлтийг тулгалт хийж хэвших
- 3.1.7 Шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмжийг биелүүлж ажиллах.


3. ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Байхгүй.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР:  Л.ЭРДЭНЭЧИМЭГ

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ:  Л.ОДОНТУЯА

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА:  П.НАРАНМАНДАХ

НЯГТЛАН БОДОГЧ:  Б.БОЛОР-ЭРДЭНЭ

**СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН БАРИМТАД
ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр

/хавсралт №1/ /мян.төг/

| № | Зөрчил | Акт | | | Албан шаардлага | Зөвлөмж | Хуулийн байгууллагад шилжүүлсэн | Зөрчлийн нийт дүн | Хариуцах эзэн |
|-----------------|--|------------|----------------------|-----------|-----------------|-----------------|---------------------------------|-------------------|---------------|
| | | Орон нутаг | Тухайн байгууллага Д | Хувь хүнд | | | | | |
| 1 | Анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна | | | | | 6,088.80 | | 6,088.8 | |
| 2 | Дотоод журмыг баримталж ажиллаагүй. | | | | | 1,704.0 | | 1,704.0 | |
| 3 | анхан шатны баримтын бүрдэл дутуу | | | | | 1,000.0 | | 1,000.0 | |
| 4 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй. | | 1,001.90 | | | | | 1,001.9 | |
| Нийт дүн | | - | 1,001.90 | - | - | 8,792.80 | - | 9,794.70 | |

ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ ГАРГАСАН:

ДОТООД АУДИТОР:.......... Л.ЭРДЭНЭЧИМЭГ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АКТ

2023 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 2023/01-21

Сүмбэр сум,

Нөхөн төлбөр тогтоох тухай

Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн баталсан 04 тоот удирдамжаар Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагааг, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, журмуудын хэрэгжилтийг шалгах зорилгоор хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/86 тоот захирамжаар Монгол улсын төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одон”-гоор шагнагдсан Хишигтийн Чулуунбаатар, Дэлхийн зөн байгууллагад хүндэтгэл үзүүлэх зардалд 1,001.9 мянган төгрөгийн зарцуулсан, уг зардлыг гаргахдаа холбогдох тайлан гаргаагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг бүхэлд нь, Төрийн хэмнэлтийн тухай 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.5 дэх заалтуудыг тус тус зөрчжээ.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйл, “Төсвийн тухай” хуулийн 69 дүгээр зүйл, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2 дахь заалт, Засгийн Газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Хууль зөрчиж олгосон 1,001.9 мянган төгрөгийг шийдвэр гаргасан албан тушаалтнуудаар нөхөн төлүүлэх

2.Дээрх 1,001.9 мянган төгрөгийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны дотор төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь Гс.МХГазар-орлогын 100220000982 тоот дансанд төвлөрүүлэхийг Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын дарга П.Наранмандах, нягтлан бодогч Б.Болор-Эрдэнэ нарт актаар хариуцуулав.

4202305050

3.Гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14.1, Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 486 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

Актыг

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ: Л.ОДОНТУЯА



ХҮЛЭЭН АВСАН:

ДАРГА: П.НАРАНМАНДАХ
НЯГТЛАН БОДОГЧ: Б.БОЛОР-ЭРДЭНЭ

